

БАТЛАВ: ТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАЛ
БӨГӨӨД ЕРӨНХИЙ
ИНЖЕНЕР

Б ДАШДАВАА

220/110/35/10 кВ-ын Тавантолгой дэд станцад аваари бүртгэх
(АУРА маягийн) автомат төхөөрөмж суурилуулах зураг
төсөл боловсруулах даалгавар

Дугаар...07/2020/01

2020 оны 03 сарын 19 өдөр

Улаанбаатар хот

1. **Байршил:** Өмнөговь аймаг Цогтцэций сум
2. **Ерөнхий чиглэл:** 220/110/35 кВ-ын “Тавантолгой” дэд станцад Аваари бүртгэх (АУРА маягийн) автомат төхөөрөмж суурилуулах.
3. **Техникийн үндсэн нөхцөл:**
 - Аваари бүртгэх (АУРА маягийн) автомат төхөөрөмжөөр тоноглох, зураг төслийн тооцоогоор сонгох,
 - Тавантолгой дэд станцын РХА-ийн төхөөрөмжийн хуучин ажиллаж байсан зарчмыг алдагдуулахгүйгээр хийж гүйцэтгэх.
 - ЭХС –ийн хэмжээнд урьд ашиглаж байсан, логик ажиллагаа болон шаардагдах техникийн нөхцлийг хангасан микропроцессорны баазтай төхөөрөмжийг суурилуулах шаардлагатай. Эдгээр солигдох төхөөрөмж нь тухайн дэд станцад ашиглагдаж байгаа бүх тоноглолын мэдээллийг бүрэн авдаг байхаар сонгох.
 - Дэд станцын хэвийн горимыг хянах бололцоо бүхий, үүнд тухайн дэд станцын ачаалал, таслуур, хуурай салгуур, газардлагын хутгын байрлалуудыг бүрэн харуулна. /СКАДА болон мониторингийн системүүд/ хяналтын системд бүрэн дэмждэг байх шаардлагатай. IRIG-B системээр синхрон цаг тааруулдаг байх.
 - Аваари бүртгэх төхөөрөмж, түүний бусад тоног төхөөрөмжүүд нь үйлдвэрийн баталгаат зураг схем, зураг дизайн холболттой байх ба эдгээр нь үйлдвэрийн баталгаатай иж бүрдэл бүхий төхөөрөмж байна.

Угсралтын ажлын үед тавигдах шаардлага:

- Угсралтын ажил дууссаны дараа техникийн паспорт, ашиглалтын заавар, зураг, схем ийн иж бүрдүүлэлтийг ЦДҮС ТӨХК-д хүлээлгэн өгнө. .
- Шинээр суурилуулах АУРА-ын холболт, газардуулах байгууламж, туслах тоноглолын зураг, техникийн өгөгдөл зэргийг албан тоотоор ЦДҮС ТӨХК-д ирүүлж танилцуулан зөвшөөрөл авсан байх.
- Системийн блок тоосжилтоос бүрэн хамгаалагдсан, Хөргөлтийн системийг хянадаг, тэжээл нь аккумулятор бүхий UPS суурилуулах.

- Газардуулах байгууламжийг норм дүрмийн дагуу хийх ба ТАД-ийн 5.4.10 заалтын дагуу шинээр суурилуулах тоноглолын байнгын газардуулгыг дэд станцын газардуулгын системд холбох
- Энэхүү техникийн даалгавар олгогдсон өдрөөс эхлэн 1 жилийн хугацаанд хүчинтэй

Хянасан: 

Д.Чинбат / Техникийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /



М.Өмербай / Шуурхай зохицуулалтын хэлтсийн дарга /



Н.Батбаяр / Реле хамгаалалт, туршилт хэмжүүрийн хэлтсийн дарга /

Боловсруулсан:  Ш. Мөнхжаргал / Зураг төслийн инженер /